

**Монголын банк бус санхүүгийн  
Байгуулагуудын холбоо  
Банк бус санхүүгийн байгууллагуудтай хийх  
гишүүнчлэлийн гэрээ**

2020 оны ... сарын . . . өдөр

№.....

Улаанбаатар хот

Энэхүү гишүүнчлэлийн гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Холбооны дүрмийг үндэслэн, нэг талаас Монголын банк бус санхүүгийн байгуулагуудын холбоо (цаашид “Холбоо” гэх)-г төлөөлж, Гүйцэтгэх захирал албан тушаалтай А.Мөнхбаяр, нөгөө талаас “..... ББСБ” ХК (цаашид “Гишүүн” гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал албан тушаалтай ..... нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Гэрээний зорилго, нөхцөл**

- 1.1 Энэхүү Гэрээний зорилго нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Холбооны Дүрэм болон Ёс зүйн дүрмийг үндэслэн гишүүдийн хууль ёсны нийтлэг эрх ашгийг хамгаалах болон Холбооны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах, Талуудын эрх, үүргийг тодорхойлох, гишүүнээр элсүүлэх, гишүүнчлэлээс хасахтай холбоотойгоор үүссэн харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 ББСБ нь, Холбооны үйл ажиллагааны талаарх аливаа мэдээлэл, Холбооны дүрэм болон Ёс зүйн дүрэмтэй танилцсаны үндсэн дээр хүсэлт гаргасны дагуу энэхүү Гэрээг байгуулж байна.

**Хоёр. Холбооны эрх, үүрэг**

- 2.1 Холбооны гишүүдийн хууль ёсны эрх, нийтлэг ашиг сонирхлыг хуулийн хүрээнд төлөөлөн хамгаалах, санал, санаачилга гаргах, энэ чиглэлээр гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах, нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах;
- 2.2 Банк бус санхүүгийн байгууллагын салбарын стратеги, бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагааг дэмжиж ажиллах, төрийн болон олон улсын байгууллага, бусад холбогдох этгээдтэй хамтран ажиллах;
- 2.3 Салбарын зах зээл, гишүүдийн нийтлэг эрх, ашиг сонирхолд нийцсэн, тэдгээрийг хамгаалахуйц стратеги төлөвлөгөө, бодлого боловсруулж ажиллах;
- 2.4 Гишүүнээс хууль ёсны нийтлэг ашиг сонирхлын хүрээнд ирүүлсэн санал, хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэж, хариу мэдэгдэх;
- 2.5 Холбооны үйл ажиллагаатай холбоотойгоор Гишүүн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийн санг бий болгоход гишүүн байгууллагуудтай хамтран ажиллах, гишүүн байгууллагуудын аливаа мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцыг хадгалах.
- 2.6 Гишүүний жилийн татварыг хүлээн авах, түүнийг батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу захиран зарцуулах;  
Гишүүний мэдээлэл, техник технологид суурилсан үйл ажиллагааг дэмжиж ажиллах
- 2.7 Гишүүн байгууллагуудын үйл ажиллагаа, нийгэмд оруулж буй хувь нэмрийг сурталчлах, түгээх, олон нийтэд таниулах;
- 2.8 Гишүүн байгууллагын ажилтнуудын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалт, семинар, уулзалтыг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах, хамруулах;

- 2.9 Мэргэжлийн туслалцаа, үйлчилгээ үзүүлэхэд гишүүн байгууллага, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;
- 2.10 Төр, төрийн бус байгууллага, олон нийтэд хандаж гишүүн байгууллагууд болон салбарын эрх, ашиг хөндөгдсөн аливаа асуудлаар судалгаа шинжилгээ хийж хамтын зарчмаар шийдвэрлэх арга хэмжээ авах;
- 2.11 Холбооны дүрэм, Ёс зүйн дүрэм болон салбар, гишүүн байгууллагуудын аливаа нийтлэг эрх, ашиг сонирхлын хүрээнд гаргасан Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэхийг шаардах эрхтэй;
- 2.12 Гишүүн нь Холбооны дүрэм, энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх
- 2.13 Холбооны дүрэм болон Ёс зүйн дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.

### **Гурав. Гишүүний эрх, үүрэг**

- 3.1 Холбооны үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам болон бодлогыг дагаж мөрдөх, идэвх санаачилгатай хамтран ажиллах;
- 3.2 Гишүүн нь Холбооны үндсэн зарчим, бодлого, дүрэм, жишгийг чанд даган мөрдөж ажиллах бөгөөд зөрчсөн аливаа эс үйлдэхүй, үйлдэл гаргасан тохиолдолд хариуцлага хүлээх;
- 3.3 Холбооны үйл ажиллагаанд өөрийн төлөөлөх эрх бүхий этгээдийг томилон оролцох ба Гишүүн байгууллагын төлөөлөгч нь Холбооны дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 3.4 Холбооны үйл ажиллагаа болон чиг үүрэгт хамаарах асуудлаар мэдээ, мэдээлэл авах, үйл ажиллагааны тайлантай танилцах;
- 3.5 Холбооны нэр хүндийг дээдлэн, бусад гишүүдийн нийтлэг эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, Холбооны дүрэм, Ёс зүйн дүрэм, бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөх, тэдгээрийг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх;
- 3.6 Гишүүн нь Холбооны нэр хүнд, үйл ажиллагаанд нөлөөлөх нийгэм рүү чиглэсэн арга хэмжээг дангаар хэрэгжүүлэх тохиолдолд урьдчилан Холбоонд мэдэгдэж зөвшилцөх;
- 3.7 Салбарын болоод Холбооны бодлого, төлөвлөгөөнд хохирол учруулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх;
- 3.8 Холбоо, түүний бусад хамтран ажиллагч байгууллагуудын зохион байгуулж буй арга хэмжээ, сургалт, хурал семинар, уулзалтанд оролцох, төлбөрийн хөнгөлөлтийг эдлэх;
- 3.9 Холбооноос тодорхой хугацаанд төлөвлөж хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд тогтоосон хугацаанд нь оролцож чадаагүй, санал, санаачилга ирүүлж амжаагүйгээс өөрт учирсан хохирол, эрх, ашиг сонирхлыг Холбооноос шаардах эрхгүй;
- 3.10 Холбоо болон түүнтэй хамтран ажилладаг гэрээт байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг тэдний байгуулсан гэрээний дагуу хөнгөлөлттэй үнээр авах.
- 3.11 Холбооны болон салбарын шагналд байгууллага, ажилтнаа нэр дэвшүүлэх, дэмжлэг, тодорхойлолт хүсэх;
- 3.12 Холбооны үйл ажиллагааны талаар санал шүүмжлэл гаргах, хууль, дүрмийн хүрээнд холбогдох мэдээллийг гаргуулах.
- 3.13 Өөрийн хүсэлтээр холбооны гишүүнчлэлээс татгалзах, энэ тухай Холбоонд албан тоотор эсхүл цахим шуудангаар мэдэгдэх.
- 3.14 Энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг Холбооноос шаардах эрхтэй.
- 3.15 Монгол Улсын хууль тогтоомж болон Холбоотой байгуулсан энэхүү гэрээ болон Холбооны дүрэм, Ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллах.
- 3.16 Гишүүн байгууллага болон салбарын нийтлэг ашиг сонирхлын хүрээнд Холбооны Удирдах зөвлөлөөс гаргасан зөвлөмж, хууль ёсны үүрэг даалгавр, бусад журмыг биелүүлэх үүрэгтэй.

- 3.17 Хууль, дүрэм, журмын төслүүдэд санал өгөх, гишүүдийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг хамгаалах чиглэлээр зохийн байгуулсан аливаа арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцох.
- 3.18 Холбооны зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэх бусад аливаа үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, саналаа өгөх.
- 3.19 Гишүүн байгууллагуудын үйл ажиллагааны талаарх мэдээллийн сан буй болгоход Холбоотой хамтран ажиллах, мэдээллийг Холбоонд хагас жил тутам гаргаж өгөх үүрэгтэй.
- 3.20 Холбооны үйл ажиллагаанд санхүүгийн болон бусад төрлийн дэмжлэг үзүүлэх үүрэг, амлалт өгсөн бол Холбооноос тогтоосон хугацаанд биелүүлэх.
- 3.21 Холбооны дүрэм болон Ёс зүйн дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх.
- 3.22 Гишүүн байгууллага нь Холбооны дүрэмд заасны дагуу Гишүүний хураамжийг Холбооны бүх гишүүдийн хурлаар тогтоосон хэмжээгээр тухайн оны эхний улиралд багтаан жилд нэг удаа төлөх ба МББСБХолбооны “Худалдаа хөгжлийн банк /ХХБ/” дахь төгрөгийн 499053088 тоот дансанд нэхэмжлэх өгснөөс хойш ажлын 5 /Тав/ өдөрт багтаан төлөх.

**Дөрөв. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, сунгах, цуцлах,  
Гишүүнчлэлээс татгалзах ба сэргээх**

- 4.1 Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон Холбооны дүрэм, Ёс зүйн дүрэмд үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт орсон бол энэхүү гэрээг өөрчлөх үндэслэл болно.
- 4.2 Гишүүн байгууллага нь энэхүү гэрээний 3.13-д заасны дагуу өөрийн хүсэлтээр холбооны гишүүнчлэлээс татгалзсан тухайгаа Холбоонд албан тоотоор эсхүл цахим шуудангаар мэдэгдээгүй, Холбооны ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу Холбооны гишүүнчлэл, Удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаагүй бол, мөн энэхүү гэрээний 4.1-д заасан нөхцөлийн дагуу гэрээнд өөрчлөлт ороогүй бол, хамгийн сүүлд гишүүний хураамж төлсөн өдрөөс хойш 12 (Арван хоёр) сар, түүнээс илүүгүй хугацааны дотор дараа жилийн гишүүний хураамжаа төлсөн бол гэрээг 12 (Арван хоёр) сараар сунгасанд тооцно.
- 4.3 Энэхүү гэрээний 3.22 болон 4.2-д тогтоосон өдрөөс хойш ажлын 10 (Арав) өдөрт багтааж гишүүний хураамжаа төлөөгүй тохиолдолд гишүүнчлэлээс татгалзаж, гэрээ цуцлагдсанд тооцно.
- 4.4 Энэхүү гэрээний 3.13-д заасны дагуу өөрийн хүсэлтээр холбооны гишүүнчлэлээс татгалзах, эсхүл Холбооны Ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу Холбооны гишүүнчлэл, Удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл хамгийн сүүлд гишүүний хураамж төлсөн өдрөөс хойш 12 (Арван хоёр) сарын дотор дараа жилийн гишүүний хураамжаа төлөөгүй бол гишүүнчлэлээс татгалзсанд тооцож, гэрээ цуцлагдах үндэслэл болно.
- 4.5 Энэхүү гэрээний 3.13-д заасны дагуу өөрийн хүсэлтээр холбооны гишүүнчлэлээс татгалзах, эсхүл Холбооны Ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу Холбооны гишүүнчлэл, Удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан шалтгаанаар гэрээ цуцлагдсан тохиолдолд гишүүний хураамжийг ББСБ-д буцаан олгохгүй.
- 4.6 Холбооны Ёс зүйн дүрмийн 7.1-д заасны дагуу Холбооны гишүүнчлэл, Удирдах зөвлөлөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргаснаас бусад шалтгаанаар гэрээ цуцлагдсанаас хойш хуанлийн 30 /Гуч/ хоногт гишүүнчлэлээ сэргээх хүсэлт өгөх эрхтэй ба гэрээ сунгасанд тооцогдоно.

## Тав. Бусад зүйл

- 5.1 Энэхүү Гэрээгээр нарийвчлан зохицуулаагүй бусад харилцааг Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон Холбооны дүрэм, Ёс зүйн дүрмээр зохицуулна.
- 5.2 Энэхүү Гэрээг зөрчсөн гишүүн байгууллагад сануулга хүргүүлэх, Удирдах зөвлөлөөс хасах, нэр дэвшүүлэхгүй байх болон гишүүнчлэлээс хасах хүртэлх арга хэмжээг Холбооны дүрэм, ёс зүйн дүрмийн дагуу авч хэрэгжүүлнэ.
- 5.3 Гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх бөгөөд эс чадваас уг маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 5.4 Гэрээг 2/Хоёр/ хувь үйлдэн талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

МББСБХолбоо-г төлөөлж:

Гишүүн байгууллагыг төлөөлж:

Гүйцэтгэх захирал

..... ББСБ ХХК

А.Мөнхбаяр

Гүйцэтгэх захирал

/..... /

/ .....

И-мэйл: [info@bbsb.mn](mailto:info@bbsb.mn)

И-мэйл:

Утас: 77008380

Утас: